



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/247

Улаанбаатар хот

Түр заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн хүнийг гэрээр хянах, эмчлэх түр зааврыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын бэлэн байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.


3. Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн хүнд гэрээр эмчлэх, хянахад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн зах зээлийн нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар (Н.Гэрэлт-Од), хүний нөөцийг чадавхжуулахад чиглэсэн сургалтыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа), Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөл (Д.Мягмарцэрэн)-д тус тус даалгасугай.

4. Коронавируст халдвар (COVID-19)-ын тархалт, эмнэлгийн тусламж, үйлчилгээний нөхцөл байдалд үндэслэн уг тушаалыг хэрэгжүүлж эхлэх шийдвэрийг гаргаж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газрын дарга (Я.Буянжаргал), "Шинэ коронавируст халдварын эмнэлгийн бэлэн байдлыг хангаж ажиллахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөн туслах чиг үүрэг бүхий эмнэлзүйн зөвлөх баг"-т тус тус даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт үүрэг болгосугай.


САЙД

Д.САРАНГЭРЭЛ



- 141200873

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04
дүгээр сарын 17 өдрийн А/297 дугаар
тушаалын хавсралт



Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн хүнийг гэрээр хянах, эмчлэх түр заавар

Коронавируст халдвар (COVID-19)-ын илрүүлэлт

Томуу, томуу төст өвчний (Халуурсан, ханиалгасан, хоолой хөндүүрлэсэн, хамар хуурайшсан) зовууртай иргэн утсаар болон биечлэн хандсан тохиолдолд өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн дуудлага хүлээн авсан эмнэлгийн мэргэжилтэн нь дараах асуумжийг тодруулна. Үүнд:

- 14 хоногийн хугацаанд халдвар бүртгэгдсэн бүс нутагт зорчсон эсвэл оршин сууж байсан эсэх,
- Өвчилсөн болон халдварын сэжигтэй хүнтэй ойр байсан эсэх,
- Хэрвээ "ТИЙМ" бол "Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй тохиолдлын тархвар судалгааны хуудсыг заавал бөглүүлнэ.

Өвчтөнийг эрэмбэлэн гэрээр эмчлэх эсэхийг шийдвэрлэх

Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй болон дараах эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээг өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн хяналтад гэрээр үзүүлнэ.

Хөнгөн хэлбэрийн эмнэлзүйн шинж тэмдэг:

- бага зэрэг халуурах (38 хүртэл)
- ханиалгах
- бие сульдах
- хоолой хөндүүрлэх

Хөнгөн шинж тэмдэгтэй боловч дараах эрсдэлт бүлгийн хүнийг гэрээр эмчлэхгүй

- 60-аас дээш настай
- жирэмсэн
- хүүхэд
- зүрх, судас, уушги, элэг, бөөр, бодисын солилцооны архаг суурь өвчтэй
- сэтгэцийн эмгэгтэй
- дархлаа дарангуйлагдах эмгэгтэй
- дархлаа дарангуйлах эм хэрэглэж буй

Гэртээ эмчлэх эсэхийг тухайн өвчтөнд илэрч буй эмнэлзүйн шинж тэмдгээс гадна гэрийн орчин нөхцөлийг харгалзан шийдвэрлэнэ.

- гэртээ халдвараас сэргийлэх дэглэмийг сахих боломжгүй,
- ам бүл олон
- гэр бүлийн гишүүд дотор ахмад настан, архаг суурь өвчтэй 5 хүртэлх насны хүүхэдтэй
- нийтийн байр, оюутны байранд амьдардаг хүнийг гэрээр эмчлэхгүй.

Гэрийн эмчилгээний хяналт

- Гэрээр эмчлэгдэх хүнийг бүрэн эдгэртэл сум, өрх, тосгоны эмч байнгын холбоотой байж, биеийн байдал, илэрч буй эмнэлзүйн шинж тэмдгүүдийг утсаар тогтмол лавлан шаардлагатай зөвлөгөө мэдээлэл, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- Шаардлагатай тохиолдолд гэрийн эргэлт, үзлэг хийж, шинжилгээ авна.

Эмчилгээ:

1. Дэглэм

Хагас хэвтрийн дэглэм сахих, шим тэжээлтэй, халуун хоол, унд хэрэглэж, сэтгэлзүйн хувьд тайван байлгах.

2. Дэмжих эмчилгээ

- а. Хордлого тайлах: амаар халуун бүлээн шингэн уулгах,
- б. Дархлаа дэмжих: витамин С хоногт 1000 мг уух
- с. Шинж тэмдгийн эмчилгээ. Хэрэв биеийн халуун 38°C-аас дээш байвал халуун бууруулах Парацетамол 500 мг-аар өдөрт 2-3 удаа 3 хүртэл хоног уух

3. Уламжлалт анагаах ухааны эмчийн хяналтад идээ унд, явдал мөр, эмийн болон засал эмчилгээг хийнэ.

Нянгийн халдвар хавсарсан, хүндэвтэр болон хүнд хэлбэрийн шинж тэмдгүүд илэрвэл эмнэлэгт хэвтүүлэн эмчилнэ.

Гэрийн эмчилгээг хийж буй тохиолдолд халдвараас сэргийлэх дэглэм

- Өвчтөний ар гэрийнхэн, асран хамгаалагчдад хувийн ариун цэвэр сахих, өвчтөнг асрах, гэрийн нөхцөлд халдвар дамжихаас сэргийлэх талаар дараах зөвлөмжийг өгнө.
 - Өвчтөнг агааржуулалт сайтай өрөөнд байлгана.
 - Өвчтөнг нэг эрүүл хүн асарч, сувилна.
 - Гэр бүлийн бусад гишүүдээс тусад нь өөр өрөөнд байлгах, боломжгүй бол өвчтөний орыг гэр бүлийн бусад гишүүдээс нэг метрээс доошгүй зайд байрлуулна.
 - Өвчтөнийг гэрээс гаргахгүй бөгөөд өрөөний цонхыг нээж, агааржуулна.
 - Өвчтөн ариун цэврийн өрөөг хэрэглэсэн тохиолдол бүрт ахуйн хэрэглээний цэвэрлэгээний бодисоор цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.
 - Асарч байгаа хүн өвчтөний өрөөнд орох бүртээ, амны хаалт зүүнэ.
 - Өвчтөнг асарч дуусаад гараа угааж амны хаалтыг тайлсны дараа давтан гараа савантай бүлээн усаар сайтар угаана.
 - Хоол идэхийн өмнө болон дараа, ариун цэврийн өрөөнд орсны дараа, өвчтөний бие түүний эргэн тойронд хүрэлцсэн бол гараа савантай бүлээн усаар заавал угаана.
 - Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх бодис хэрэглэж болно. Уг халдваргүйжүүлэх бодисыг залгих, уухаас сэргийлэх, галын аюулгүй байдлыг хангана.

- Гараа савандаж угаасны дараа нэг удаагийн алчуур, салфетка хэрэглэх, боломжгүй бол даавуун алчуурт арчин ба хэрэглэсэн алчуурыг сайтар савандаж угаана.
- Өвчтөн ханиах, найтаах үед нэг удаагийн алчуур, салфетка хэрэглүүлж, хэрэглэсэн алчуур, салфеткийг шууд хаяна, эсвэл гарыг нугалж, тохойн дотор тал руу ханиаж, найтаалгана.
- Өвчтөний нус, цэр, шүлс, шээс, өтгөн, цусанд хүрэлцэхээс зайлсхийх, тэдгээрт хүрэлцэх, цэвэрлэх үедээ ус нэвтэрдэггүй материалаар хийсэн хормогч, нэг удаагийн бээлий өмсөх ба тэдгээрийг тайлах бүртээ гарын ариун цэврийг сайтар сахина.
- Өвчтөн болон өвчтөнийг асрахад хэрэглэсэн бээлий, салфетка, амны хаалт, бусад хог хаягдлыг тусад нь савлаж хаяна.
- Өвчтөний ахуйн хэрэгслийг гэр бүлийн гишүүдийнхээс тусад нь байршуулах, (шүдний сойз, хоолны хэрэгсэл, алчуур, орны цагаан хэрэглэл) гал тогоо, хоолны хэрэгслийг зориулалтын бодистой халуун усаар сайтар угаана. Хэрэглэсэн усыг дахин ашиглахгүй байх;
- Усаар шингэрүүлсэн цайруулагчийн (белизна) уусмалаар өвчтөний ор түүний орчимд байрлах ширээ болон бусад эд хогшлыг өдөр бүр цэвэрлэж, хаалганы бариулд хүрсэн тохиолдол бүрийн дараа угаана. Усаар шингэрүүлсэн уусмалыг бэлтгэхдээ 99 мл усанд 1 мл цайруулагч бодис (белизна) байхаар тооцно.
- Өвчтөний өмссөн хувцас, хэрэглэсэн орны цагаан хэрэглэл, гар, нүүрний болон биеийн алчуур зэргийг тусгай уут, саванд хийж цельсийн 60-90°C хэмийн халуун усанд гараар эсвэл угаалгын машинд угаах, харин сэгсрэх болон арьсанд хүргэхээс зайлсхийнэ.

Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй болон эмнэлзүйн хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн хүнтэй хавьтал болсон хүмүүс, эмнэлгийн мэргэжилтнүүд 21 хоногийн турш өөрсдийн биеийн байдлыг ажиглаж, халуурах, ханиалгах, амьсгалахад саадтай болох, гүйлгэх зэрэг эмнэлзүйн шинж тэмдгүүд илэрсэн тохиолдолд эмнэлэгт яаралтай хандахыг зөвлөж байна.

ooOoo